

## ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2015 оны 2 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар... 01

Улаанбаатар хот

Энэхүү “Хамтран ажиллах гэрээ” /цаашид “гэрээ” гэх-г Монгол Улсын Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулийг тус тус үндэслэн, Нэг талаас МУИС-ийг төлөөлж Сургалт эрхэлсэн дэд захирал Проф.О.Мөнхбат, нөгөө талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж, МУИС-ийн хичээлийн VI байр, 208 тоот хаят орших МУИСОХ Төрийн бус байгууллагыг төлөөлж тэргүүн Д.Энхтөр /цаашид “МУИСОХ, ОК” гэх/ дор дурьдсан нөхцөөр харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

- 1.1. Уг гэрээний зорилго МУИС нь өөрийн оюутан суралцагчид үзүүлэх зарим үйлчилгээг МУИСОХ, ОК-гоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Уг гэрээний хүрээнд дараах зарчмыг баримтлана:
  - 1.2.1 Талууд оюутны эрх, нийтлэг ашиг сонирхлыг хамгаалахдаа боловсролын тухай хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, журамыг удирдлага болгоно.
  - 1.2.2 Талууд асуудалд судалгаа, тооцоонд үндэслэн бодитой хандах, тодорхой санал, шаардлагыг албан бичгээр мэдэгдэж, хариу авах хэлбэрнийг баримтлан ажиллана.
  - 1.2.3 Талууд аливаа асуудалд зөвшүүлж, харилцан ойлголцож шийдвэрлэхийг эрмэлзэж, хууль дээдлэх, шударга ёс, дүрэм журамын хүрээнд харилцан туслалцан ажиллана.
  - 1.3. Гэрээний хугацаанд үе шаттай хэрэгжүүлэх тодорхой ажлуудын жагсаалтыг энэхүү гэрээнд хавсаргах бөгөөд гэрээний бүрэлдэхүүн хэсэг болно.

### ХОЁР ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

- 2.1. МУИС дараах эрх эдэлж, үүрэг хүлээн. Үүнд:
  - 2.1.1. МУИС нь оюутанд үзүүлэх үйлчилгээг сургалтын нэгдсэн албаны чиг үүрэгт заасны дагуу тухайн хичээлийн жилд төлөвлөх, хэрэгжүүлэх, дүгнэх бөгөөд шаардлагатай зарим үйлчилгээг МУИСОХ-той хамтран болон дагнан гүйцэтгэж болно.
  - 2.1.2. МУИС нь МУИСОХ-ны үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, гэрээгээр гүйцэтгүүлж буй ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлэхийг шаардах, үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээ цуцлах, төлбөрийг зогсох эрхтэй.
  - 2.1.3. МУИС нь Оюутны Конгрессин үйл ажиллагаа МУИС-ийн эрхэм зорилгод нийцэн эсэхэд хяналт тавих, МУИС-ийн нутаг дэвсгэрт улс төр, шашны үйл ажиллагаа явуулахгүй байхыг шаардах, зөрчсөн тохиолдолд гэрээг хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.
  - 2.1.4. МУИС нь сургалтын орчин нөхцөл, хичээлийн болон оюутны байрны ашиглалт, тохиижилт, хангамж үйлчилгээний талаар МУИСОХ-ноос гарсан санал хүсэлтийг төсөв санхүүгийн боломжийн хүрээнд үе шаттайгаар шийдвэрлэх үүрэг хүлээн.
  - 2.1.5. МУИСОХ-оос оюутны эрх, нийтлэг ашиг сонирхолыг хамгаалах чиглэлээр өгсөн үндэслэл бүхий асуултын хариултыг албан бичгээр өгнө.
- 2.2. МУИСОХ Оюутны Конгресс дараах эрхийг эдэлж үүргийг хүлээн. Үүнд:
  - 2.2.1. Оюутны холбоо, оюутан конгрессийн гишүүн, сонгуультан сурлага, хүмүүжлийн талаар бусад оюутнаа манлайлан МУИС-ийн оюутнуудад сурч боловсрох, хөгжихөд тус нэмэр болохуйц ажил үүргийг гүйцэтгэж, чанартай хүртээмжтэй үйлчилгээ үзүүлнэ.
  - 2.2.2. Оюутны зарим үйлчилгээг гэрээний дагуу биелүүлж буй тохиолдолд шаардлагатай төсөв санхүүжилт авах, уг зориулалтаар анги танхим, спорт урлагийн заалтыг сургалт эрдэм шинжилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр ашиглаж болно.

2.2.3. МУИС-ийн оюутны байгууллагын үйл ажиллагаанд зориулсан нэгдсэн офисын байр, гэрэл, цахилгаан, ус, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу үнэ төлбөргүй ашиглана.

2.2.4. Оюутны холбоо үйл ажиллагааны залгамж холбоог үргэлжлүүлэх бөгөөд тухайн жилийн санхүү болон үйл ажиллагааны тайлан, бусад албан тоотууд, ирсэн явсан бичиг хэргийн албан хэрэг хөтөлтийн журмын дагуу архивт очиж хадгалуулна.

2.2.5. МУИСОХ нь оюутны өмнө тулгамдаж буй асуудлаар МУИС-ийн захиргаа, холбогдох албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр санал оруулна.

2.2.6. МУИСОХ нь их сургуулийн төсөв санхүүжилтээр гүйцэтгэх оюутны үйлчилгээг МУИС-ийн оюутны үйлчилгээ хариуцсан алба, мэргэжилтний заавар, зөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх бөгөөд сонгуульт хугацаанд хийж гүйцэтгэсэн оюутанд зориулсан үйл ажиллагааны нэгдсэн тайланг жилд хоёроос доошгүй удаа 3 ба 10-р сард нэгтгэн Сургалт эрхэлсэн дэд захиралд хүргүүлж дүгнүүлнэ.

2.2.7. МУИСОХ нь гэрээ болон гэрээний хавсралтад заасан үйл ажиллагааны хэрэгжилтийг МУИС-ийн захиргаанаас шаардах эрхтэй.

#### ГУРАВ. САНХҮҮЖИЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

3.1. Тухайн жилийн санхүүжилтийн хүсэлт, ажлын төлөвлөгөөг МУИС-ийн төсвийн хүрээнд талууд хамтран тодорхойлно.

3.2. Санхүүжилт нь жил бүрийн 01 сарын 01-ний өдрөөс тухайн жилийн 12 сарын 31-ний өдөр хүртэл байна.

3.3. Үйл ажиллагааны санхүүжилт:

3.3.1. МУИС нь МУИСОХ-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай бичгийн хэрэгсэл, хувилах, хэвлэх хор зэргийг зохих журмын дагуу хичээлийн жилд 2 удаа зохих журмын дагуу ханган нийлүүлнэ.

3.3.2. МУИС нь гэрээний хавсралтанд заасан оюутны зарим үйлчилгээг МУИСОХ-гоор хамтран болон дангаар гүйцэтгэх тохиолдолд төсөвт заасан санхүүжилтийг хариуцан хийнэ.

3.3.3. МУИС нь төлөвлөсөн оюутны үйлчилгээнээс бусад нэмэлт санхүүжилт, мөнгөн тусламж хандив өгөх зэрэг үүрэг хүлээхгүй.

3.4. Үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл:

3.4.1. МУИСОХ нь санхүүгийн тайлан тооцоог холбогдох дүрэм журмын дагуу хийнэ.

3.4.2. Төвлөрсөн үйл ажиллагааны төсвийн болон үйл ажиллагааны тайланг үйл ажиллагаа явагдаж дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан МУИСОХ-ны Хяналтын зөвлөлөөр хянуулан, тус бүр 3 хувь үйлдэж, МУИС-ийн Сургалтын нэгдсэн алба, Санхүү эдийн застийн хэлтэст хүргүүлнэ.

3.4.3. Бүрэлдэхүүн /салбар/ сургуулиудын төсвийн болон үйл ажиллагааны тайланг үйл ажиллагаа явагдаж дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан Оюутны зөвлөлийн хяналтын алба болон МУИСОХ-ны Хяналтын зөвлөлөөр хянуулан бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албаны асуудал хариуцсан мэргэжилтэн болон нягтлан бодогчид хүргүүлнэ.

#### ДӨРӨВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1. МУИСОХ гэрээний үүргээ биелүүлээгүй, санхүүгийн зөрчил гаргасан тохиолдолд ажлын 10 хоногт багтаан ажлын доголдлыг арилгаагүй тохиолдолд санхүүжилтийг зогсох, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хуулийн байгууллагад өгөх хүртэл арга хэмжээ авна.

4.2. МУИС гэрээний заалтуудыг зөрчсөн тохиолдолд холбогдох этгээдэд МУИС-ийн хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага тооцно.

4.3. МУИСОХ, Оюутан Конгрессийн сонгуульт албан тушаалтан гэрээний заалт зөрчсөн тохиолдолд түүнд сануулах, анхааруулах, үүрэгт ажлаас чөлөөлөх, санхүүгийн зөрчил гаргасан тохиолдолд хохирлын барагдуулж, МУИСОХ хяналтын зөвлөлийн ажиллах журмын дагуу шийдэж, сонгуульт ажлаас чөлөөлнэ.

## ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 5.1. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулсан өдрөөс эхэн хүчин төгөлдөр болсонд тооцогдоно.
- 5.2. Талууд харилцан токиролцсоны үндсэн дээрээс гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 5.3. Энэхүү гэрээний 3.2 дугаар заалтын дагуу гэрээний хугацаа 1 жил байх бөгөөд гэрээний хүчинтэй хугацаанд алз нэг тал гэрээ цуцлах санал тавих хүртэл гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 5.4. Гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
- 5.4.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, гэрээ дүгнэсэн.
- 5.4.2 Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл бүрдсэн.
- 5.5. Гэрээтэй холбогдон гарах аливаа асуудлыг талууд зөвшилцлийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд тийнхүү зөвшилцэн шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

<p>ГЭРЭЭ БАЙГУУЛСАН</p> <p>МУИС-ийг төлөөлж: Сургалт эрхэлсэн дэд захирал  Проф. Д-р О.Мөнхбат/ утас: 976-11-324385 Факс: 976-11-324385 И-мэйл: <a href="mailto:munhbat@num.edu.mn">munhbat@num.edu.mn</a> Вэб: <a href="http://www.num.edu.mn">www.num.edu.mn</a></p>	<p>МОНГОЛ УЛСЫН ИХ СҮРГҮҮЛИШ</p> <p>МУИС-Оюутны холбоот төлөөлж: Оюутны холбоо, Оюутан Конгрессийн тэргүүн  Д.Энхтер/ Утас: 976-9999-2287, 7730730-7000 И-мэйл: <a href="mailto:togoo Devil@yahoo.com">togo Devil@yahoo.com</a> Вэб: <a href="http://www.num.edu.mn">http://www.num.edu.mn</a></p>
--	--

МУИС-ийн оюутны Уйлчилгээний чилэлтэр МУИСОХ ТББ-тай хамтран буюу гэрэлэн гийн эхийн экил Уйлчилгээ, төлөвлөсөн төсөв

2014-2015 оны хичээлийн жилд

хамрак хугацаа: 2015.1.1-2015.12.31

№	Гүйцэтгэх Үйл ажиллагаа	Ажлын зорилго/ тайлбар	Хэрэгжүүлэх х хугацаа	Үндсэн гэрээгээ Гөгөвлюсөн	Төсөв ₮	Хамрах хэрээ
1	Шинэ оюутан чиглүүлэх хөтөлбөр	МУИС-д шинээр элссэн оюутнуудад таништуулахаар	9 сард	СНА, БССА, МУИСОХ	50000	Шинэ элсэтийн
2	Клубуудын танилцуулах нээлттэй өдөрлөг	Клубууд гишүүнчлээ нэмэгдүүлэх	9 сард	МУИСОХ КЗ	50000	Нийт оюутнууд
					100000	
3	Оюутны төлөөллийн байгууллагын гишүүдийг чадавхрекуулах, хөтөкүүлж сургалт	Гишүүдийг хөтөжүүлснээр цашид оюутнуудаа хөтөкүүлэх боломж олгож	5 сард	МУИСОХ	250000	Идэвхитгэн гишүүд
4	“МУИС-ийн түх” ЭШХ	МУИС-ийн оюутан зарууст УУСГЭН байгуулагчийнcaa түүхий мэдх, таних, бахархах сэлэл герүүлэх	2 сард	МУИСОХ	600000	Нийт оюутнууд
5	МУИС-ийн Оюутны Эрдэм шинжилгээний ногдсан хурал	Судалгааны эжлын чадварыг эзэмшиүүлэх, залуу судлаачдыг дээмжих зорилготой Бакалавр, магистр, доцторын эрдэм шинжилгээний нийт оюутныг хамарсан хурал	3, 4, 5 сард	МУИСОХ, БС, ЭШХ	3800000	Нийт оюутнууд
6	Хувь хүнийг чаивархуулах "Бүтээлч оюутан" цогц сургалтууд	Боловчуулсан хотолбөрийн дату сургалг баш нар, лекторуудыг урьж сургалт зохион байгуулнаар Хувь хүний хөгжүүлэх, төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах	Жилийн турши	СНА, МУИСОХ	4500000	Нийт оюутнууд
					9150000	

Уралдаан тэмцээн						
7	Илтгэлийн тэмцээн	Илтгэх чадварыг хөгжүүлэх	3,4 сард	МУИСОХ, ХЗС	1000000	нийт оюутнууд
8	Оюутны яруу наиргийн наадам	Оюутнуудын гоозүйн мэдлэг, мэдрэмжийг дээшүүлэх	3 сард	МУИСОХ	300000	нийт оюутнууд
9	Оюутны уран зургийн уралдаан	Оюутнуудын гоозүй, урлагийн мэдрэмжийг дээшүүлэх	4 сард	МУИСОХ	300000	нийт оюутнууд
10	Парламентын мэргэцлээн	МУИС-ийн мэргэцлээний аварга шашгаруулах	4 сард	МУИСОХ ХШУИС ОЗ	1500000	нийт оюутнууд
11	Төслийн уралдаан	Оюутанд тулгамсан асуудлаар төсвэрийг шашгаруулж хэрэгжүүлэх	5 сард	МУИСОХ ХШУИС ОЗ	600000	нийт оюутнууд
					3700000	
Уралдаан, соёлын үйл ажиллагааг дэмжих						
12	Оюутны урлагийн бага наадам, бэлгтэл ажил наадам	оюутнуудын урлагийн авьяасыг нээн ирүүлэх	11-12 сар	СНА, МУИСОХ ХЗСОЗ ХШУИС	1000000	БС оюутнууд
13	Оюутны урлагийн их наадам	МУИС-ийн нийт окоутны урлагийн чадварыг сориц, хөгжүүлэх, шилдгийг тодруулах	3 сард	СНА, МУИСОХ	8000000	нийт оюутнууд
14	"Culture day" өдөрнийг	Орон ороос суралцах буй оюутнуудаа өөрсдийн соёл, уламжлалыг танишуулах	4 сард	СНА МУИСОХ	2000000	нийт оюутнууд
15	Оюутны чөлөөт цагийн Үйл ажиллагааг дэмжих	Чөлөөт цагийн Үйл ажиллагааг СНА-ны төлөвлөөний дагуу хийж гүйцэтгэх /АХА, Алтан хонх, Happy Valentine's day, Хайлловенын баяр, Оюутны танилцах өдөрөг Г.М./				
					12200000	
Сургалт хүмүүжил, олон нийтийн үйл ажиллагааг /хөгжил, хүмүүжил, спорт эрзүүл ахий зөв даач/						
16	МУИС-ийн оюутны Спортын их наадам	Оюутнуудын эрүүл мэнд, биеийн тамирын хөгжийг дэмжих	11,12 сард	СНА, БТТ, МУИСОХ	5500000	Нийт оюутнууд

7	Сүүлийн оюутны найзаж нонордөл боломжоор хангах найзаж нонордөл боломжоор хангах	— сард	СНА, МУИСОХ	3000000   цагийн монгол оюутнууд		
18	Дотуур байрны оюутны “1000 оюутны баяр” спортын арга хэмжээ	10 сард	СНА, МУИСОХ	1000000 Дотуур байрны оюутнууд		
19	МУИС-ийн хөлбөмбөгийн аварга шалгаруулах гэмцээн	4 сард	БТГ, МУИС ХШИС ОЗ	850000 нийт оюутнууд		
20	МУИС-тай танилцах аяланы хөтөлбөр	10, 2 сард	СНА МУИСОХ	600000 МУИС-д элсэхийг хүснэгтийг		
21	СНА, МУИСОХ-ын хамтарсан сургалт, үйл ажиллагаа	сар бүр	СНА МУИСОХ	1500000 СНА, МУИСОХ		
22	“Хувийн соёл хэвшүүлэх” аяан	Хувь хүний болон харицайдын соёлыг хэвшүүлэх ёс сурхахууныг дээшшуулэх ажлыг тодорхой хугацааг хамрруулан далаитгай хийх, ҮР ДУН гаргах	11 сард	СНА МУИСОХ	2000000 нийт оюутнууд	
						14450000
<b>Тэмдэглэлт өдрийн үйл ажиллагаа</b>						
23	Олон улсын оюутны эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэх	Оюутанд мэдээлэл өгөх, санал хүснэгтийг хүлээн авах, уулзант зохиох зэрэгэр бүх оюутанд хүргээмжтэй үйл ажиллагаа зохион байгуулах	11 сард	МУИСОХ	500000 нийт оюутнууд	
24	Монголын оюутны эрхийн өдрийг тэмдэглэх	Оюутанд мэдээлэл өгөх, санал хүснэгтийг хүлээн авах, уулзант зохиох зэрэгэр бүх оюутанд хүргээмжтэй үйл ажиллагаа зохион байгуулах	3 сард	МУИСОХ	500000 нийт оюутнууд	

25	"Дээлтэй монгол" едөрлөг	Үндэсний ов соёлыг таниулах, Түгээн дэлгэрүүлэх	2 сард	МУИСОХ	1500000 нийт оюутнууд
26	ДОХ-ын эсрэг ОУ едрийг тэмдэглэх	ДОХ-ос урьдчилан сэргийлэх мэдээлэл өгөх	12 сард	МУИСОХ	50000 нийт оюутнууд
					2550000
<b>Санхүүтийн дэмжлэг</b>					
27	МУИС-д онцгой амжилттай суралцах буй оюутнуудыг дэмжих	амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур, хөтөлийн бэрхшээлтэй, өнчин суралцаачийг дэмжих		СНА МУИСОХ	2500000
					2500000
<b>Хөдөлмөр эрхэлэлтийг дэмжих үйл ажиллагаа</b>					
28	Хөдөлмөрийн яармаг, уулзаптуудыг зохион байгуулах	Байгын болон түр, тагийн ажлын байранд зуучлах, ажлыг олготг болон оюутны холбож бөхөх	4,5 сард	СНА, МУИСОХ, ОХЭДА	2800000 нийт оюутнууд
29	Хөдөлмөр эрхэлтийг дэмжих бусад арга хэмжээ	Ажлын байранд бэлтгэх сургалтууд зохион байгуулах, шаардлагатай мэдээ түрш мэдээллийр хангах	Жилийн түрш	СНА, МУИСОХ, ОХЭДА	2500000 нийт оюутнууд
					5300000
<b>Бусад</b>					
30	Оюутны Уйлчилгээний мэдээлэл түгээх самбарын байгын ажиллагааг хангах	Өдөр тутмын мэдээлэл түтэх, самбарын байгын ажиллагааг хангах	3 сард	СНА, МУИСОХ, ГХХМА	1300000 нийт оюутнууд
31	Мэргэжил сургалчлах өдөр ... гэх мэт/	Мэргэжил сургалчлах/хуульчдын шинээр мөрдөгдөж буй болон оюутнуудад таниулах	9, 12 сард	БССА, БСОЗ, ТЭХМУУД	100000 нийт оюутнууд
32	МУИС-ийн дүрэм журмыг сургалчлах таниулах ажиллагаа	МУИС-д мөрдөгдөж буй болон шинээр дүрэм журмыг нийт оюутнуудад таниулах	Жилийн түрш	СНА МУИСОХ К3	700000 нийт оюутнууд
33	Оюутанд тулгамсан асуудлын талаархи судалгаа хийх	Оюутны санал хүснэгтийг хүлээн авч, холбогдох нэгжид уламжлан шийдвэрлүүлэх		СНА, МУИСОХ, ОГСХАА	250000 нийт оюутнууд

34	Санал хүснэгтийн хайрцаг ажилуулах	Оюутны санал хүснэгтийг авах, хайрцгийн байнгын ажиллагааг хангах турш	Жилийн турш	МУИСОХ ӨГСХАА	315000 нийт оюутнууд
35	ашибан хэрэгцээнний зардал	Хангальтын үйл ажиллагаа явуулах, албан ёсны хаягжилт. Үйл ажиллаганд /нэрийн хуудас, хаяг,./	5 сард	МУИСОХ, ХЗА	400000 нийт оюутнууд
36	Клубуудын зөвлөлийн үйл ажиллагааг илрэвхижүүлэх	Нэг оюутан-нэг клуб хөтөлбөр хэрэгжүүлэх, клубын Үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллас	4 сард	СНА МУИСОХ, КЗ	2000000 нийт оюутнууд
37	Тайллан танилцуулах 24-р чуулган	Бүх хийсэн ажилуудаа тайлагнах, дүгнүүлэх	4 сард	МУИСОХ	4500000 нийт оюутнуудад
38	Цахим номын сантай болох	Оюутны суралч орчин хангах, илүү зардлыг хэмнэх, номын зардал хэмнэх, цахим номын весб шинээр хикж сургуулийн вэбгийн холбох	3 сард	МУИСОХ, ХШУИС	1000000
39	Номын сангийн үйл ажиллагааг сурталчлах	Номын сангийн Үйлчилгээ, Үйл ажиллагааг хүргэмжтэй болгох	10, 4 сард	СНА, Номын сан, МУИСОХ	400000 нийт оюутнууд
<b>Бүтэл дүн</b>					
<b>57215000</b>					

Бэлтгэсэн: Б.Энххаргал